

**“Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн 2018 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан**

Эрүүл мэндийн газар

2018.11.28

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Засгийн газрын 11 дугаар тогтоолоор батлагдсан “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”	<b>Зорилго:</b> Халдварт өвчнийг тандах, сэргийлэх, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг уян хатан, чанартай, хүртээмжэй, шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлэхэд бусад салбарын оролцоог нэмэгдүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах замаар халдварт өвчний тархалтыг бууруулахад оршино.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө
3.	Хэрэгжүүлэгч байгууллага хэрэгжих нийт хугацаа: 2017-2021 он	Бүх шатны Эрүүл мэндийн байгууллага Төрийн болон төрийн бус байгууллагууд
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1. Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалтыг эрчимжүүлэх, дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тохиолдол, эндэгдлийг бууруулна.</p> <p>Зорилт 2. Хепатитийн вирүст халдвараас урьдчилан сэргийлэх, халдварыг эрт илрүүлэх, хүн амын дундах вирүсийн халдварын тархалтыг хязгаарлах, өвчлөл, нас баралтыг бууруулна.</p> <p>Зорилт 3. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвар, цартахал, томуу, томуу төст өвчний тандалтыг өргөжүүлэх замаар хариу арга хэмжээний бэлэн байдлыг ханган орчны бохирдолтой холбоотой халдварт өвчний дэгдэлтээс сэргийлэх, тандах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилт 4. Сүрьеэ өвчний илрүүлэлт, оношилгоо, эмчилгээнд шинэлэг аргыг нэвтрүүлж, салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг цогц байдлаар үзүүлнэ.</p> <p>Зорилт 5. БЗДХ, ХДХВ-ын халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн цогц, чанартай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж халдварын</p>

		тархалтыг бууруулна. Зорилт 6. Зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих, зоонозын анзаарагддаггүй зарим өвчний тандалтын тогтолцоог өргөжүүлэх, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний чадавхийг сайжруулна. Зорилт 7. Талбарын тархвар судлалын сургалтын хөтөлбөрийг сайжруулах, эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны чадавхийг бэхжүүлнэ.							
5.	Зардал	Төсөв (Нийт шаардагдах)							
		Үүнд:	Төсөв (он)			Гүйцэтгэл		Хувь	
		Багц 1							
		Багц 2 (г.м)							
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Биелэлт						
	1-р зорилтын хүрээнд:		а/ Товлолын дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралтын судалгаа эхний шатандаа буюу 25-30 хувьтай явагдаж байна. Дархлаажуулалтын цахим бүртгэлийн мэдээллийн санг 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор үүсгэсний дараа цахим бүртгэлээс товлолын дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралтын судалгааг гарган бүрэн тундаа хамрагдаагүй хүүхдийг нөхөн дархлаажуулалтад хамруулах боломжтой болно.						
	1.1	Товлолын дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралтын судалгаа хийх	б/ Аймгийн төвийн 6 сургууль, 7 цэцэрлэгийн эмч, нийгмийн ажилтан, арга зүйч нарт сургалтыг хийсэн. Сургалтад нийт 28 хүн хамрагдсан бөгөөд сургалтаар дархлаажуулалтын мэдлэгийн түвшинг үнэлэх зорилгоор сургалтын өмнө 15 асуулттай тестээр мэдлэгийн түвшинг үнэлэн үзэхэд мэдлэгийн түвшин 64,5 хувьтай үнэлэгдсэн бөгөөд товлолын дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсаны ач холбогдол, дархлаажуулалтад хамрагдахын өмнө, вакцин хийх үед болон вакцины хийсний дараа анхаарах зүйлс гэх мэт сургалтыг хийсний дараа 85,2 хувь болж мэдлэгийн түвшин нэмэгдсэн.						
1.2	Хүйтэн хэлхээний тоног	а/ 2018 онд аймгийн хэмжээнд дархлаажуулалтын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж нийт							

<p>төхөөрөмжийн багтаамжийг нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний зардлыг төсөвт суулгах</p> <p>а/ Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын вакцин, биобэлдмэлийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, холбогдох арга хэмжээг авна.</p> <p>б/ Анхан шатны эмнэлэгүүдэд хүйтэн хэлхээний тандалтыг тасралтгүй хийх, “Дархлаажуулалтын 10 хоног” зохион байгуулах</p>	<p>хэвийн ажиллагаатай 25 хөргөгч, 2 хөлдөөгчтэй бөгөөд 11 хөргөгч 10-аас дээш жил ажилласан байна. Үүнээс 1996 онд ашиглалтанд орсон буюу 21 жил ажиллаж байгаа ЭМГ-ийн 1 хөргөгч, 1998 онд ашиглалтанд орсон буюу 19 жил ажиллаж байгаа Сэврэй ЭМТ, Цогт-Овоо ЭМТ-ийн 2 хөргөгч, 1999 онд ашиглалтанд орсон буюу 18 жил ажиллаж байгаа Баян-Овоо ЭМТ, Өнө-Орших ӨЭМТ, Энхийн хүслэн ӨЭМТ-ийн 3 хөргөгч 2002-2006 онд ашиглалтанд орсон буюу 11-15 жил ажиллаж байгаа 5 хөргөгч байна.</p> <p>Эхний ээлжинд олон жил тасралтгүй ажиллаж байгаа Ханбогд СДЭ, Сэврэй ЭМТ, Цогт-Овоо ЭМТ, Баян-Овоо ЭМТ, Өнө-Орших ӨЭМТ, Энхийн хүслэн ӨЭМТ-ийн хөргөгчийг солих шаардлагатай байгаа албан тоотыг ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хүргүүлсэн. Мөн 2019 оны үндсэн чиглэлд хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн 15 сая төгрөгийн зардлыг тусгасан.</p> <p>б/ Монгол улсын эрүүл мэндийн сайдын А/191 тоот тушаалаар батлагдсан Дархлаажуулалтын 10 хоногийг “Дархлаажуулалтын бүртгэл, мэдээллийг цахимжууль” уриан дор зохион байгуулан ажилласан. Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийн цахим программыг нэвтрүүлэх 9 заалттай үйл ажиллагааны төлөвлөгөө ЭМГ-ын даргаар батлуулан сумын ЭМТ, СДЭ, ӨЭМТ-рүү хүргүүлсэн.</p> <p>1. Дархлаажуулалтын бүртгэл мэдээллийн цахим программ нэвтрэх үеийн бэлтгэл ажил буюу Компьютер, принтер, интернетийн холболтыг шалгах, бэлэг байдлыг хангах мөн Дархлаажуулалтын мэдээллийн сан бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>• Харьяаллын 3 хүртлэх насны хүүхдийн бүртгэлийг шинэчлэх, түр оршин суугч, бүртгэлгүй хүүхдийг бүртгэлжүүлэх</li> <li>• Хүүхдийн эхийн овог нэр, регистерийн дугаар, холбоо барих утасны дугаарын жагсаалтыг бэлтгэх</li> <li>• Хүүхэд бүрийн “ Урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ”-г “ Эх хүүхдийн дэвтэр” Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн бүртгэлтэй”-тэй тулгаж,</li> </ul>
---	---

		<p>мэдээлэл бүрэн бус тохиолдолд нөхөж бичих, дахин гэрчилгээжүүлэх 2018 оны 7 сарын 31 өдөр гэхэд дуусгасан байна.</p> <p>2.Товлолын дархлаажуулалтаас хоцорсон хүүхдүүдийн судалгааг нэрсээр гарган эмч нараар дамжуулан мэдээ хүргэж 206 хүүхдийг нөхөн дархлаажуулалтад хамруулсан.</p> <p>3.Дархлаажуулалтын ач холбогдолыг ард иргэдэд суртчилах үүднээс 10 төрлийн зурагт хуудас, 4 төрлийн бичлэг, 1 шторк бэлдэн өөрийн цахим хуудас болон эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хуудсанд байршуулан суртчилсан.</p> <p>Ээлжит дархлаажуулалтын 10 хоногийн үйл ажиллагааг 2018 оны 10 дугаар сарын 10-20 өдрийн хооронд <b>“Вакциндаа хамрагдъя, Хамтдаа сэргийлье”</b> уриан дор зохион байгуулсан бөгөөд товлолын дархлаажуулалтаас хоцорсон 219 хүүхдийг нөхөн дархлаажуулалтад хамруулсан болон Сахуу татрангийн эсрэг дархлаажуулалтад 7 насны 1356-1354 хүүхэд хамрагдан 2 хүүхэд хоцорсон, 15 насны 761-758 хүүхэд хамрагдан 3 хүүхэд хоцорсон. Мөн эцэг эх ард иргэдэд сахуу татрангийн эсрэг дархлаажуулалтын талаарх мэдээллийг хүргэсэн.</p>
	<p>1.3 Хүний нөөцийг тасралтгүй бэлтгэх, давтан сургах</p> <p>а/ Дархлаажуулалтын чиглэлээр сургалтанд анхан шатны ЭМТ-ын сувилагч, вакцинолог, түр орлох ажилчдыг үе шаттай бэлтгэх, давтан сургах</p>	<p>а/ 2018 оны 10 дугаар сарын 08-09-ны өдрүүдэд “Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалт”-ын бүсчилсэн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад Говьсүмбэр, Дундговь, Төв аймгийн нэмт-ийн дарга, халдвар судлаач, хүүхэд, нярайн эмч,дархлаажуулалт, эмийн асуудал хариуцсан мэргэжилтэн, аймгийн ЭМБ-ын эрхлэгч зэрэг нийт 37 хүн хамрагдсан.</p> <p><b>Сургалтын үр дүн:</b> Оролцогч аймгуудын мэргэжил нэгт хүмүүсээс туршлага судалсан болон аюулгүй дархлаажуулалт, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалтын талаарх мэдлэг сайжирсан.</p> <p>Анхан шатны Эрүүл мэндийн төвийн вакцинолог, түр орлон гүйцэтгэх сувилагч нарт 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нийт 38 хүнд “Дархлаажуулалтын цахим бүртгэл, дархлаажуулалтын талаарх бодлогын бичиг баримт, вакцин хамралт, вакцины төрөл, вакцины нөөцийн менежмент, зарцуулалт, вакцин тээвэрлэлт,</p>

		<p>хадгалалт, устгал, ДДУХ-ын тандалт хариу арга хэмжээ гэх мэт хичээлүүд онол, дадлага хосолсон сургалт болсон.</p> <p>Сургалт зохион байгуулагдсанаар вакциначтор, түр орлон гүйцэтгэх сувилагч нарын мэдлэг сайжирсан.</p> <p>Орон нутагт өөрсдийн боломжоор хүний нөөцийг сургах чиглэлд дэмжлэг үзүүлсэн буюу орон нутгийн санхүүжилтээр Булган, Ханхонгор СЭМТ, Өнө-Орших ӨЭМТ-н нийт 3 вакциначтор сувилагч нар ХӨСҮТ-ийн мэргэжил дээшдүүлэх 3-н сарын сургалтад хамрагдсан.</p>
	<p>1.4 УУ-ын эсрэг товлолын дархлаажуулалтын бүрэн тунд хамруулах</p> <p>а/ Дархлаажуулалтаас хоцорсон хүүхдийн судалгаа гаргаж нөхөн дархлаажуулах</p> <p>б/ Улаанбурхан өвчний дэгдэлт, бүртгэгдсэн сэжигтэй тохиолдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах</p> <p>в/ Сайн дурын дархлаажуулалтанд хамрагдах эрсдэлт бүлгийг судалж, ач холбогдолыг сурталчилах, хамрагдалтыг нэмэгдүүлэх</p>	<p>а/ Товлолын дархлаажуулалтаас хоцорсон хүүхдийг ямар вакцины хэд дэх тунд хоцорсон хүүхдийн судалгааг сар бүр нэрсээр гарган сум, өрхийн эрүүл мэндийн төвийн вакциначтор сувилагч нарт хүргүүлэн хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулалтад хамруулдаг. 2018 оны эхний 10 сарын байдлаар 853 хүүхэд нөхөн дархлаажуулалтад хамрагдсан.</p> <p>б/ 2018 онд Улаанбурхан өвчний дэгдэлт сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.</p> <p>в/ ХӨСҮТ-ийн ерөнхий захирлын 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/101 тоот тушаалын дагуу улирлын томуугийн эсрэг вакцинаар эмнэлгийн ажилчдын 1350 хүн, жирэмсэн 300 хүн, архаг хууч өвчтэй 150 хүн, сайн дурын дархлаажуулалтад 250 хүнийг хамруулсан буюу хамралт 100 хувьтай байна.</p>

<p>2-р зорилтын хүрээнд:</p> <p>2.1 Хүн ам, эрсдэлт бүлгийн дунд хепатитийн вирүст халдварын талаар болон эрсдэлт зан үйлийг өөрчлөх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэн зохион байгуулах</p> <p>а/ эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн ажилтан, хепатитийн В вирүст халдварын эсрэг вакцинаар үе шаттай дархлаажуулах</p> <p>б/ Дэлхийн хепатитийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх</p> <p>в/ Хүн ам, эрсдэлт бүлгийн дунд хепатитийн вирүст халдварыг илрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах Элэг бүтэн Монгол, Элэг бүтэн Өмнөговь хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх</p>	<p>а/ 2018 онд 18-39 насны ард иргэдэд Хепатитын В вирус<span></span>ын эсрэг сайн дурын дархлаажуулалтад нийт 1150 хүн хамрагдсан 1-р тунд 448 2-р тунд 488 3-р тунгаа бүрэн авсан 214 хүн байна.</p> <p>2018 онд Хепатитын В вирус<span></span>ын эсрэг дархлаажуулалтад огт хамрагдаж байгаагүй нийт 44 эмнэлгийн ажилчдыг тархвар судлалын заалтаар Хепатитын В вирус<span></span>ын 1-2-р тунгаар дархлаажуулсан. Хепатитын В вирус<span></span>ын эсрэг СДД-ад 1330 хүн хамрагдсан.</p> <p>б/ Жил бүрийн 7 дугаар сарын 28-ны өдрийг “Вируст хепатиттай тэмцэх дэлхийн өдөр” болгон тэмдэглэж байхаар шийдвэрлэсэн бөгөөд манай улс найм дах жилдээ тэмдэглэн өнгөрүүлжээ. Энэ жилийн “Вируст хепатиттай тэмцэх дэлхийн өдөр”-ийг <b>“Хепатитыг Илрүүлье, Эмчилъе”</b> уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн. Төрийн болон ТББ, ХХЭМ-ийн байгууллагуудын оролцоотойгоор иргэдийн вирус хепатитаас урьдчилан сэргийлэх, мэдээлэл сургалт сурталчилгаа, зөвлөгөө зөвлөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үзлэг оношилгооны чанар, хяналтыг сайжруулах олон талт чиглэсэн үйл ажиллагааг зохион явуулсан.</p> <p>Нийт 15 сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нэгдсэн дүнгээр өдөрлөгийн үйл ажиллагаанд 1500 гаруй иргэн, 26 албан байгууллагуудыг хамруулсан байна. Вируст хепатитаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмжийг 922 хүнд, сургалт, мэдлэг мэдээллийг 710 хүнд, үзлэг шинжилгээг 829 хүнд хийж ӨЭМТ-ийн төвийн эмч, лаборант, эмийн сангийн эм зүйч нар дэлгэрэнгүй мэдээллийг өгсөн. Цахим орчинд зөвлөмж мэдээллийг 200 гаруй хүнд хандалт хийсэн байна. “Түвшин” хэвлэлийн газраар 30 ширхэг гарын авлага, “Сэтгэшгүй хойч” ХХК-аар өдөрлөгийн баннар, 50 ширхэг сургалтын урилга, 2 төрлийн 300 ширхэг мэдээлэл сургалт сурталчилгааны материал хийлгүүлэн хамтран ажилласан байна.</p> <p>Өдөрлөгийн үр дүнд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж, үзлэг шинжилгээний хамралт</p>
---	---

		<p>нэмэгдсэн байна.</p> <p>в/ Хөтөлбөрийн хүрээнд 15-65 насны нийт 7360 хүнийг хамруулсан байна. Үүнээс С вирустай 330, В вирустай 347 хүн оношлогдож нийтдээ С вирус тоолуулах шинжилгээнд илгээсэн сумын эрүүл мэндийн төвөөс 323, Даланзадгад сумаас 438 хүний сорьц илгээгдсэн байна. Эмчилгээнд хамрагдсан нийт 829 иргэн үүнээс С вирус 647, В вирус 182 байна. С вирус тэглэсэн 480 хүн байна. БОЭТөвийн элэгний үйл ажиллагаа тодорхойлох лабораторын шинжилгээний урвалж оношлуурын хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор 15 сая төгрөгийн ажлыг зохион байгуулсан байна. Хөтөлбөрийн 2-р шатны нээлтийн үйл ажиллагааг өргөн хүрээнд зохион байгуулан нийтдээ 6000 гаруй иргэнийг хамруулсан томоохон үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан байна. Элэг бүтэн Өмнөговьчууд хөтөлбөрийн болзолт уралдаан, багийн эмчийн болзолт уралдааныг зарлан үйл ажиллагаанд 3,500,000 төгрөг зарцуулахаар төлөвлөн идэвхижүүлэн ажиллаж байна. Сум өрхийн эрүүл мэндийн төвийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 12 сая төгрөгийн төсвийг хөтөлбөрийн зардлаас шийдвэрлүүлэн сумдад хуваарилсан байна. Хөтөлбөрөөс 50 сая төгрөгт мобайл тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийсэн байна. Элэг бүтэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нийтдээ орон нутгийн төсвөөс 100 сая төгрөгийг төсөвлөн төсвийн зарцуулалт 98%-тай хэрэгжиж байна.</p>
--	--	--

<p>2.2 ЭМБ-уудад халдвараас сэргийлэх хяналтын тогтолцоог бэхжүүлэх, халдваргүйтгэл ариутгалын орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах</p> <p>а/ Эмнэлгийн халдваргүйтгэл, ариутгалын орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах</p> <p>б/ ЭМБ-уудад халдвар хяналтын ажилтан бэлтгэх</p> <p>в/ Эмнэлгийн үйлчлэгч нарт сургалт хийх</p> <p>г/ Хог хаягдлын сургалтыг давтан хийх, эмнэлгүүд дотоодоо дахин сургалт хийх</p>	<p>а/ 2018 оныг АЗДаргын захирамжаар "Эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарлаж хүний нөөц, багаж төхөөрөмжийн хангалт, барилга дэд бүтцийн хөгжилд 5.9 т.б төгрөгийг төсвөлсөн билээ. Үүний хүрээнд сум өрхийн эмнэлгүүдэд орон нутгийн төсвөөс 15 нэр төрлийн оношилгоо, эмчилгээ, ариутгал, яаралтай тусламжийн 105 000 000 төгрөгний өртөг бүхий багаж тоног төхөөрөмжөөр хангагдсанаар сум өрхийн стандарт хангалт 8-10%-р өсөж, сум өрхөөс иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн. Үүнд Эмнэлгийн халдваргүйтгэл, ариутгалын автоклав, бикс, кварц зэрэг багаж тоног төхөөрөмжөөр хангасан.</p> <p>б/ ХӨСҮТ-тэй хамтран ЭМБ-уудад халдвар хяналтын ажилтан бэлтгэх сургалтыг 2018 оны 4 сарын 25-нд хийсэн. Сургалтанд БОЭТ-ийн 11 тасгийн ахлах сувилагч, 14 сумын ахлах сувилагч, хувийн эмнэлгийн төлөөлөл нийт 30 хүн оролцсон. Сургалтаар эмнэлгийн халдвар хамгаалал, өөрийгөө үнэлэх, эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн ариутгал халдваргүйтгэл, ариутгалын бодисын нөөц, хангалт, зарцуулалт гэх мэт хичээлүүд онол, дадлага хосолсон 2 өдрийн сургалт болсон.</p> <p>Сургалт зохион байгуулагдсанаар шинээр халдвар хяналтын ажилтан бэлтгэгдэн ЭШХ-ын тандалт эмнэлгийн тусламж үйлчилгээ сайжирсан.</p> <p>2018 оны 11 сард сургалтыг давтан зохион байгуулахдаа эмнэлгүүдийн халдвар хяналтын багийн гишүүдийг хамруулснаар багийн хамтын ажиллагаа сайжирсан. Давтан сургалтанд сум, өрх, хувийн хэвшил, БОЭТөвүүдийн халдвар хяналтын багийн 50 эмч, мэргэжилтнүүд хамрагдаж, сургага багш гэрчилгээ олгосон.</p> <p>в/ 2018 оны 3 сарын 1-нд БОЭТ-ийн үйлчлэгч нарт сургалтыг хийсэн. Сургалтанд 21 хүн хамрагдсан бөгөөд ЭМС-ын 2017 оны 505 тоот тушаал, ЭМС-ын 186,187 тоот тушаалын цэвэрлэгээ үйлчилгээний чиглэлээр сургалтыг хийсэн. Үйлчлэгч нарын мэдлэг сайжирч, эмнэлгийн дотоод халдвараас сэргийлэх нөхцөл бүрэлдсэн.</p> <p>г/ 3 сарын 12-14-нд "Хог хаягдлын менежмент" сургалтыг Эрүүл мэндийн төсөл-5 тай хамтран зохион байгуулсан. Сургалтанд БОЭТ-ийн тасгуудын ахлах сувилагч,</p>
---	---



		<p>Ханбогд, Гурвантэс сумын сувилагч нар хамрагдсан. Нийт 30 хүнд ЭМС-ын 2017 оны 505 тоот “ ЭМБ-ын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” тушаалыг хэрхэн хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг онол, дадлага хэлбэрээр зохион байгуулж, оролцогчдын мэдлэг сургалтын өмнө 61,2, сургалтын дараа 80% болж сайжирсан.</p> <p>Давтан сургалтыг 4 сарын 12нд “Зөвлөх профессор” төслийн хүрээнд 70 эмнэлгийн тусгай дунд мэргэжилтнүүдэд ЭМС-ын 2017 оны 505 тоот тушаал хог хаягдлын менежментийн сургалтыг хийсэн. ЭМС-ын 2017 оны 505 тоот “ ЭМБ-ын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” тушаалыг хэрхэн хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг онолын хэлбэрээр давтан хийснээр мэдлэг баталгаажсан.</p> <p>Мөн 11 сард Хог хаягдлын менежмент сургалтыг давтан эмнэлгүүдийн халдвар хяналтын баг, эмийн сангийн мэргэжилтнүүдэд хийсэн.</p> <p>2018 онд нийтдээ “<b>Хог хаягдлын менежмент</b>” сургалтыг ЭМГ-аас 4 удаа, эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо 5-6 удаа сургалтыг давтан хийж, эмнэлгийн 420 гаруй эмч, мэргэжилтнүүдийг хамруулснаар эрүүл мэндийн байгууллагууд хог хаягдлын нэгдсэн урсгалтай болж аймгийн төвд /БОЭТ-д/ эмнэлгийн аюултай хог хаягдлыг халдваргүй болгох хог хаягдлын түр байрыг ашиглалтад оруулсан байна.</p>
	<p>3-р зорилтын хүрээнд:</p> <p>3.1Халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед эрсдлийн үнэлгээ хийх болон халдварт өвчнөөс сэргийлэх, хянах</p>	<p>а/ Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний эрсдлийн нөөцийн санг болзошгүй цар тахал, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний хүрээнд нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Нөөцөд нэг удаагийн өмсгөл 500, ариутгал халдваргүйтгэлийн бодис 1500, бусад эм тарианы нөөцийг эмнэлгүүд бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>б/ 2018 оны 3 сарын 20-21ны өдрүүдэд Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион</p>

<p>а/ Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний эрсдлийн нөөцийн санг (санхүүгийн болон эм, урвалж, оношлуур, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмж г.м) бий болгох, нөхөн хангалт хийх</p> <p>б/ Салбар хоорондын мэдээлэл солилцох уулзалт зохион байгуулах</p> <p>в/Халдварт өвчнийг тандах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлэх зорилгоор бүсчилсэн “Сургалт – өдөрлөг” зохион байгуулах</p>	<p>байгуулах хүрээнд “Шувууны томуугийн вирүст халдварын тохиолдлыг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх” сургалтыг орон нутагт АЗДТГ, ЭМГ, ХӨСҮТ-тэй хамтран зохион байгуулсан. Сургалтанд салбар хоорондын 10 байгууллагын 40 хүн оролцсон.</p> <p><b>Сургалтын онцлог, үр дүн:</b> Хилийн боомтын мэргэжилтнүүд оролцсноор хилээр дамжих халдвараас сэргийлэх мэдлэг, дадлагатай болсон.Салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулж нэгэн зэрэг мэдээлэлтэй болсон</p> <p>в/ Халдварт өвчнийг тандах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлэх зорилгоор бүсчилсэн сургалтыг төлөвлөсөн боловч санхүүгийн бэрхшээлээс болж хийгдээгүй.</p> <p>Халдварт өвчнийг тандах зорилгоор ЭМС-ын 121 тоот тушаалыг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд халдварт өвчнийг мэдээллэх журамыг сайдын тушаалын дагуу мэдээлж байх сэрэмжлүүлэгийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Халдварт өвчний 7 хоног тутмын мэдээллийг нэгтгэн эргэн мэдээллийг улирал бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр сэрэмжлүүлэг, зөвлөмж хэлбэрээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. 2018 онд халдварт өвчний сэрэмжлүүлэг 6, зөвлөмж 8 удаа гаргаж эргэн мэдээлсэн байна.</p>
<p>3.2 Иргэд, залуучууд, олон нийтэд чиглэсэн МСС-ны материал боловсруулах, хэвлүүлэх</p> <p>а/Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлсэн гарын авлага, санамж, боршур боловсруулах, хэвлүүлэх</p>	<p>а/ Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох, мэдлэг хандлага, дадал төлөвшүүлэх зорилготой мэдээлэл, сургалт, сурталчилгаа, өдөрлөг, компани ажил, тэмцээн уралдаан зэрэг төрлүүдэд нийт 21560 хүнийг хамруулж ажилласан байна.</p> <p>Үүнээс ард иргэдэд чиглэсэн тэнхэмийн сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг 15 удаа зохион явуулж сургалтаар 5310 иргэнийг хамруулж эрүүл мэндийн боловсрол мэдлэгийг дээшлүүлснээр иргэдийн мэдлэгийн түвшин сургалтын төгсгөлд өмнөхөөсөө 30-50 хувиар нэмэгдсэн үр дүн ажиглагдаж байна.</p> <p>Ард иргэдэд сэрэмжлүүлэг, санамж, зөвлөмж, ном, гарын авлага, зурагт хуудас, үзүүлэн зэрэг нийт 14-20 гаруй төрлийн 32400 гаруй ширхэг сургалт, сурталчилгааны материал</p>

	<p>боловсруулж тараасан байна.</p> <p>Аймгийн албан ёсны вэб хуудсанд 190 удаагийн сурталчилгаа, мэдээлэл байршуулж, 19 Facebook хуудсаар 3134 мэдээлэл, сурталчилгаа хийж, 12397 хүн хандаж мэдээллийг авсан байна.</p> <p>Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг АЗД-ын дэргэдэх олон нийттэй харилцах алба, ТҮ-үүдээ нэгдсэн удирдлагаар ханган идэвхтэй хүргэх хөдөлгөөн өрнүүлж 5 ТҮ гэрээ хийж 10 удаагийн сувилахуйн цуврал нэвтрүүлэг, 78 удаа шторк явуулсан.</p> <p>Байгууллагын facebook хуудсанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Томуугийн хүндрэл</li> <li>• Салхинцэцэг</li> <li>• Гар хөл ам – 2</li> <li>• Амны хөндийн зайлах арга</li> <li>• Галзуугийн сэргийлэлт- багшийн гарын авлага</li> <li>• Хачигт халдвар</li> </ul>
<p>3.3 Томуугийн болзошгүй цартахал, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ</p> <p>а/ Тандалтын нэгжийн эмч, мэргэжилтнүүдийг сургах</p> <p>б/ Томуугийн бэлэн байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх</p> <p>в/ Томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах зорилгод</p>	<p>а/ Аймгийн төвийн тандалтын нэгжийн эмч нарыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулснаар сорьц авах, дадлагатай болсон. Сургалтанд ӨЭМТ болон БОЭТ-ийн хүүхдийн тасаг, 103, хүлээн авах тасгийн эмч нар хамрагдсан /46/ Томуугийн дэгдэлтийн үеийн сорьц тээвэрлэлтийн бэлэн байдал хангагдсан.</p> <p>б/ Томуугийн дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, Томуу төст өвчний үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах нэгдсэн төлөвлөгөө боловсруулан ЭМГ-ын даргаар батлуулан 14 сум, 4 өрхөд хүргүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 90%</p> <p>в/ Улирлын томуугийн эсрэг вакцинаар эмнэлгийн ажилчдын 1350 хүн, жирэмсэн 300 хүн, архаг хууч өвчтэй 150 хүн, сайн дурын дархлаажуулалтад 250 хүнийг хамруулсан буюу хамралт 100 хувьтай байна.</p> <p>г/ Томуугийн вирусийн эсрэг эм, бэлдмэлийн нөөцийн бэлэн байдлыг хангах зорилгоор:</p>

<p>бүлгийн хүн амын хүрээг нэмэгдүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгааг нэмэгдүүлэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх</p> <p>г/ Томуугийн вирүсийн эсрэг эм, бэлдмэлийн нөөцийн бэлэн байдлыг хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Томуугийн зөвлөмжийг сум, өрх, БОЭТ-т 1 удаа хүргүүлсэн.</li> <li>• Дэгдэлтийн үеийн орны нөөцийг судлан ажиллаж байна. Үүнд: БОЭТ-ийн 2018 оны батлагдсан орны тоо 348 байгаа ч одоо ашиглаж байгаа ор 215 хүүхдийн тасгийн орны тоо мөн адил 40 батлагдагдсан бөгөөд одоо ашиглаж байгаа ор 24</li> <li>• Хувийн хэвшлийн ЭМБ-аас “Нинж ачлал” хүүхдийн хувийн эмнэлгийн орны тоо 11 одоогоор ашиглахгүй байгаа учир нь эмнэлгийн шинэ байр баригдаж байгаа</li> <li>• Шаардлагатай “Тамифлю” эмийн захиалга : 350 ш буюу 35 хайрцаг захиалсан.</li> </ul>
<p>3.4 Хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс сэргийлэх</p> <p>а/ Хоол хүнс, усаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх, дэгдэлтийн үеийн эрсдлийг үнэлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах</p> <p>б/ Хоол, хүнс, усаар дамжих халдварын тархалтад нөлөөлөх эрсдлийг бууруулах, стандартын шаардлага хангасан ундны усаар хүн амыг хангах, хот, суурин газрын бохир усыг цэвэрлэж байгаа түвшинд үнэлгээ хийх, хүүхдийн байгууллагад ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг мөрдүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх,</p>	<p>а/ 2018 онд хоол хүнсээр дамжих халдварын 14 тохиолдол бүртгэгдсэн. Энэ нь 1 голомттой / нэг гэр бүл, ах дүүгийн дунд/</p> <p>Амархан мууддаг хүнсний бүтээгдэхүүнийг олон цаг хадгалан хэрэглэснээс үүдэлтэй халдварын дэгдэлт гарсан. Голомтонд аймгийн МХГ, ЭМГ, БОЭТ-ийн баг хамтран ажиллан, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, тусгаарлан, эмчлэн, эрүүлжүүлэн, голомтын ариутгал халдваргүйтгэлийг цаг алдалгүй зохион байгуулснаар халдварын голомтын дэгдэлтийг таслан зогсоосон.</p> <p>б/Хоол хүнсээр дамжих халдвараас сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ бэлтгэн ард иргэдэд түгээсэн, санамж, гарын авлага, зөвлөмжөөр анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг тасралтгүй ханган ажиллаж байна. Ундны ус, бохир усны цооног, нүхэн жорлонгийн стандартыг сурталчилан ажиллаж байна.</p> <p>Даланзадгад хотын иргэдэд "Усны аюулгүй байдал ба иргэдийн усны хэрэглээ" сэдэвт 15-20 минутын 2 төрлийн нэвтрүүлгийг бэлтгэн эрүүл мэндийн газрийн болон эрүүл өмнөговьчууд пэйж хуудсанд тавьж 16000 гаруй иргэд үзсэн.</p> <p>Иргэдэд усны эрүүл ахуйн болон ус зөөх, хадгалах савны стандартын талаар мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааны 5 төрлийн 600 гаруй материалыг хүргэж ажиллаж байна. 2016- 2018 онуудад Даланзадгад сумын хэмжээнд 21 ус түгээх байранд цагийн хязгаарлалтгүйгээр усаа авах ухаалаг системийг суурилуулж, нийт 36 ус түгээх байр аюулгүй бүсээ хашаажуулаад байна.</p>

<p>дэмжлэгт хяналт хийх.</p>	
<p>3.5 Халдварт өвчний лабораторийн оношилгоо, хүний н</p> <p>а/ БОЭТ-ийн лабораторийг тоног төхөөрөмж, урвалж, оношлуураар хангах, шинэ болон сэргэж байгаа халдварын оношилгооны нөөцийн бэлэн байдлыг хангах нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх</p> <p>б/ Биологийн халдвартай байж болзошгүй сорьцийг тээвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгож жигдрүүлэх.</p>	<p>а/ БОЭТ-ийн лабораторит 2018 онд 2 ширхэг бүрэн автомат анализатораар хангаж, түргэвчилсэн урвалж, оношлуур, багажит урвалж оношлуурын нийтдээ 126 нэр төрлийн бүтээгдэхүүнээр хангагдсан байна.</p> <p>б/ Оношийн баталгаажилт хийх зорилгоор сорьцыг 3-р шатлалын лавлагаа лабораторит сорьцыг тээвэрлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулахаар 1 серологи лаборантыг ХӨСҮТ-т богино хугацааны сургалтанд хамруулснаар биологийн халдвартай байж болзошгүй сорьцийг тээвэрлэх үйл ажиллагааг жигдэрсэн.</p>

<p>4-р зорилтын хүрээнд:</p> <p>4.1 Эрсдэлт бүлгийн хүн амын дунд хийж байгаа сүрьеэг илрүүлэх идэвхтэй үзлэгийг тогтмолжуулах</p> <p>а/ Зүүн сумд, аймгийн төвийн эрсдэлт бүлгийн хүн амын дунд сүрьеэг илрүүлэх идэвхтэй үзлэгийг зохион байгуулах</p> <p>б/ Сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийг чанаржуулах</p> <p>в/ Сүрьеэгийн хавьтлыг илрүүлэх, бүрэн шинжилгээнд хамруулах</p> <p>г/ Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэх</p>	<p>а/ Сүрьеэг илрүүлэх идэвхитэй үзлэгийг Ханбогд, Цогтцэций, Цогт-овоо сумдад хийх ажлын удирдамжийг боловсруулан санхүүгийн дэмжлэг авах зорилгоор аймгийн НБХ-т хүргүүлээд байна. Дэмжигдвэл 2018 оны 12 сараас 2019 оны 1 сард багтаан хийхээр төлөвлөж байна.</p> <p>б/ Глобаль сангийн дэмжлэгтэй орон нутгийн сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, улмаар эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2018 оны эхний 10 сарын байдлаар сумаас аймаг руу 60 удаагийн давтамжтайгаар 98 хүний 196 сорьц тээвэрлэсэн байна. Сумдын сорьц тээвэрлэлтийн байдал харилцан адилгүй, тээвэрлэсэн зарим сорьцны чанар хангалтгүй /шүлсэрхэг, хэмжээ бага/, сүрьеэгийн 1 тохиолдолыг илрүүлсэн нь сард 2-с доошгүй удаа сорьц тээвэрлэх заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.</p> <p>Сорьц тээвэрлэлтийг сайжруулах зорилгоор ЭМГ, Сүрьеэгийн диспансертай хамтран “Сүрьеэгийн сорьц тээвэрлэлт, эрт илрүүлэлтийг эрчимжүүлэх нь” болзолт уралдааны удирдамжийг боловсруулан эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд оны төсгөлд хамгийн чанартай сорьц тээвэрлэсэн тээвэрлэгчийг шагнаж урамшуулах арга хэмжээ зохион байгуулж байна.</p> <p>в/ 2018 оны эхний 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт сүрьеэгийн 20 тохиолдол бүртгэгдэж, тэдний хавьтлыг 100% үзлэг шинжилгээнд хамруулсан байна.</p> <p>Сумаас эмчлэгдэж байгаа 1, өөр газраас эмчилгээнд орсон 2 хүний үргэлжлэх шатны эмчилгээг тухайн орон нутагт нь хийлгэхээр эмчилгээ хяналтын карт СУ 2, эмийн эмчилгээний зааврын хамт шилжүүлж эмийг шууд хяналттай уулгах ажлыг сумын эмчтэй хамтран хийж байна.</p> <p>г/ БОЭТ-тэй хамтран Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг угтуулан 2 сарын аяныг 2018 оны 2 сарын 20- 4 сарын 20-ны хооронд зохион байгуулах төлөвлөгөө гарган ажилласан бөгөөд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд аяны хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны чиглэлийг албан бичгээр хүргүүлсэн. 14 сум, 4 өрх, БОЭТ-с нийт 19 нэгжээс тайлан ирүүлэхээс 8 байгууллага ирүүлсэн ба хэрэгжилт 85%</p>
---	---

